

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2019 оны жилийн эцэс/

2020 оны 03 сарын 17 өдөр

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолыг тус тус удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, металл, шатах ашигт малтмалын үйлдвэрлэлийн 9 ангиллын 21 үзүүлэлтийг Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар батлагдсан. Эдгээрээс тайлант хугацаанд 10 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 11 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, үзүүлэлт буурсан гүйцэтгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд газрын тос, зэсийн баяжмал, алтны олборлолт болон экспортын хэмжээ, ОХУ-аас бусад улсаас импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ, катодын зэс, ангижруулсан төмрийн үйлдвэрлэл тус тус буурсан дүнтэй байна.

Газрын тосны олборлолт 63%, экспорт 65%-ийн тус тус гүйцэтгэлтэй гарсан нь гадаад зах зээл дээрх тосны үнэ, олборлолтын талбайн эрчим хүчний хязгаарлагдмал байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ 133%-аар, ОХУ-аас импортолсон бүтээгдэхүүний хэмжээ 146%-иар тус тус биелсэн боловч ОХУ-аас бусад улсаас импортлох бүтээгдэхүүний хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй буюу 90%-ийн биелэлттэй байна. Үүний гол шалтгаан нь БНХАУ болон бусад улсаас худалдан авах газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ өндөр байсантай холбоотой. Өөрөөр хэлбэл нэг улсаас хараат байдлыг бууруулах зорилт төдий л үр дүнд хүрэхгүй байна.

Газрын тосны үйлдвэрлэлийн тухайд дизелийн түлшний үйлдвэрлэл 330%-иар давж биелсэн байхад автобензин 29%, мазутын үйлдвэрлэл 4%-иар биелсэн нь үйлдвэрийн хүчин чадал, эрэлт хэрэгцээнд тулгуурласан төлөвлөлт хийж чадаагүйтэй холбоотой байна.

Дээрхтэй ижил нөхцөл байдал катодын зэсийн үйлдвэрлэл дээр мөн харагдаж байна. Тухайлбал 2019 онд нийт 11,7 тонн катодын зэс үйлдвэрлэсэн нь зорилтот түвшингийн 47%-ийг хангасан байна. Одоогийн байдлаар “Эрдмин” ХХК жилд 5.0 мянган тонн, “Ачит ихт” ХХК жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтайгаар ажиллаж байгаа ба нийлбэр дүнгээр жилд 11.0-15.0 мянган тонн (2015 онд 14.9 мян.тн, 2016 онд 15.1 мян.тн, 2017 онд 14.7 мян.тн, 2018 онд 14.2 мян.тн, 2019 онд 11.7 мян.тн) катодын зэс үйлдвэрлэж байна.

2018-2019 онд “Монголын алт (МАК)” ХХК жилд 5 мянган тонн, “Зэс эрдэнийн хувь” ХК жилд 10 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг бүрэн ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байсан боловч хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүйн улмаас төслүүд хугацаандаа хэрэгжээгүй ба бүтээн байгуулалтын ажлууд хойшлогдсон байна.

Ангижруулсан төмрийн тухайд “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК-ийн “Уул уурхай, металлургийн цогцолбор” байгуулах концепци төлөвлөгөө”-г “шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх”, “барих-шилжүүлэх” нөхцөлтэйгээр “Кью Эс Си” ХХК болон Эдийн Засгийн Хөгжлийн Яам /хуучнаар/-тай нь 2014 оны 04 дүгээр сард Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан байна.

Дээрх төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1-р шатны ажлууд болох төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт байгуулах ажлуудыг хэрэгжүүлэн төмрийн хүдрийн 2 уурхай нээж, уурхайнууд дээр хуурай соронзон баяжуулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэр, ган бөмбөлгийн үйлдвэр зэргийг дэд бүтцийн ажлуудын /төмөр зам, авто зам, ачиж буулгах терманалууд, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд/ хамт барьж байгуулсан.

Төслийн 2 дугаар шатанд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь жилд 500 мянган тонн шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах, мөн жилд 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлыг 2018 оны 4 дүгээр сард хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн боловч төслийн хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас бүтээн байгуулалтын ажил хугацаандаа хийгдээгүй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 97 хувьтай, 4.9 оноогоор дүгнэгдлээ.

Хавсралт:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, 1 хуудас,

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Г.Ганхүү

Танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын Шинжээч

Б.Баяржаргал /2018.03.17/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулгын хавсралт

2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр

2019 оны жилийн эцсийн байдлаар

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2016/	Эхний жил /2017 он/		2 дахь жил /2018 он/					3 дахь жил /2019 он/					Зорилтот түвшин
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Үнэлгээ		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Үнэлгээ		2020
								Хувь	Оноо				Хувь	Оноо	
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	34.6	37.0	37.4	38.4	38.7	0.3	100	5.0	41.0	43.5	2.5	106	5.0	41.0
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг зохиох төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	86.0	100.0	100.0	100.0	92.1	-7.9	92	4.6	92.0	94.0	2.0	102	5.0	/-
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ														
	Газрын тос (мянган баррель)	8,249.8	7,971.1	7,632.6	10,850.7	6,188.4	-4,662.3	57	2.9	10,899.1	6,875.5	-4,399.1	63	3.2	10,899.1
	Нүүрс (сая тонн)	35.4	47.1	47.1	37.0	50.0	13.0	100	5.0	41.1	50.8	9.7	124	5.0	41.1
	Зэсийн баяжмал (мянган тонн)	1,445.1	1,310.0	1,317.1	1,500.0	1,310.8	-189.2	87	4.4	1,820.0	1,262.4	-557.6	69	3.5	1,920.0
	Төмрийн хүдэр (сая тонн)	4.9	10.0	7.7	10.0	6.2	-3.8	62	3.1	10.0	12.0	2.0	120	5.0	10.0
	Алт (тонн)	18.4	19.8	19.8	20.0	20.7	0.7	100	5.0	23.0	16.3	-6.7	71	3.6	23.0
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ														
	Газрын тос (мянган баррель)	8,015.9	7,100.0	7,514.2	10,100.0	6,389.0	-3,711.0	63	3.2	10,100.0	6,546.6	-3,553.4	65	3.3	10,100.0
	Нүүрс (сая тонн)	25.7	33.4	33.0	25.5	35.8	10.3	100	5.0	28.0	36.6	8.6	131	5.0	28.0
	Зэсийн баяжмал (мянган тонн)	1,562.0	1,280.0	1,607.8	1,620.0	1,436.7	-183.3	89	4.5	1,720.0	1,403.6	-316.4	82	4.1	1,720.0
	Төмрийн хүдэр (сая тонн)	6.1	7.0	6.3	10.0	7.4	-2.6	74	3.7	10.0	12.0	2.0	120	5.0	10.0
	Алт (тонн)	19.2	15.0	14.6	15.0	3.4	-11.6	23	1.2	15.0	9.1	-5.9	60	3.0	15.0
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (сая тонн)	1.22	1.49	1.50	1.40	1.79	0.39	100	5.0	1.50	2.00	0.50	133	5.0	1.50
	Үүнээс: ОХУ-аас	1.16	1.44	1.46	1.30	1.79	0.49	100	5.0	1.30	1.90	0.60	146	5.0	1.30

	Бусад улсаас	0.06	0.05	0.04	0.10	0.08	-0.02	80	4.0	0.20	0.18	-0.02	90	4.5	0.20
6	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл (мян. тн)														
	Дизель түлш	30.0	30.0	32.0	30.0	29.0	-1.0	97	4.9	30.0	98.9	68.9	330	5.0	30.0
	Автобензин	15.0	15.0	20.0	15.0	3.5	-11.5	23	1.2	30.0	8.8	-21.2	29	1.5	30.0
	Мазут	5.0	5.0	10.0	5.0	3.5	-1.5	70	3.5	10.0	0.4	-9.6	4	0.2	10.0
7	Ган бүтээгдэхүүн (мянган тонн)	40.0	50.0	60.0	50.0	70.1	20.1	100	5.0	50.0	75.0	25.0	150	5.0	50.0
8	Катодын зэс (мянган тонн)	15.0	15.0	14.6	15.0	14.2	-0.8	95	4.8	25.0	11.7	-13.3	47	2.4	25.0
9	Ангижруулсан төмөр (мянган тонн)	/-/	/-/		/-/					500.0	0.0	-500.0	0	0.0	500.0
	УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ							80.6	4.0				97	4.9	

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ